



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Дүүргийн 2024 оны газар зохион
байгуулалтын төлөвлөгөөний
хэрэгжилтийг дүгнэж, 2025 оны
төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус I хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Чингэлтэй дүүргийн 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.

2.Дүүргийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

3.Дүүргийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, хэрэгжилт үр дүнг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг дүүргийн Засаг дарга (Н.Мандуул)-д үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



Т.УЛАМБАЯР

1501001 7

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн иргэдийн
Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 4 дугаар сарын
46 ны өдрийн 45 дугаар тогтоолын хавсралт

Чингэлтэй дүүргийн 2025 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөл

НЭГ. ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТАЛААР

Д/д	Хэрэгжүүлэх ажил	Хариуцах байгууллага	Хугацаа	Төлөвлөгөөнд тусгах үндэслэл
1	2	3	4	5
<i>Нэг. Хууль эрх зүйн хүрээнд хийгдэх ажил</i>				
1.	Газрын багц хуулийн төсөлд санал боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэх, дагаж мөрдөгдөх дүрэм, журмын төсөлд санал тусгуулах	НЗДТГ, НГЗБА, НХБХСГ	I-IV улиралд	Үндэсний болон бус нутгийн хэмжээний томоохон дэд бүтцийн болон бүтээн байгуулалтын төсөл хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаатай холбогдон улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээ, нийгмийн зайлшгүй хэрэгцээ, ашиг сонирхолд нийцүүлэх, газрын эдийн засгийн үр өгөөж ихээхэн нэмэгдэж байгаа зэрэг шалтгааны улмаас газрын эрхзүйн зохицуулалтыг улам боловсронгуй болгох, эрхзүйн шинэтгэл хийх, газрын нэгдсэн санг бүрдүүлэх, хөтлөх зэргээр нэгдсэн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Газрын тухай багц хууль тогтоомжуудад нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага үүссэн
<i>Хоёр. Газрын менежмент, төлөвлөлтийн чиглэлээр хийгдэх ажил</i>				
2.	Нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлуулсантай холбогдуулан хэрэгжилтийг зохион байгуулах	НЗДТГ, НГЗБА, НХБХГ, ДГЗБА	I-IV улиралд	Монгол улсын Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан "Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөө", Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.4.1 дэх заалт
3.	Нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн батлуулсантай холбогдуулан хэрэгжилтийг зохион байгуулах	НЗДТГ, НГЗБА, НХБХСГ, ДГЗБА	I-IV улиралд	Монгол улсын Засгийн газрын 2018 оны 384 дүгээр тогтоолоор батлагдсан "Улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөө", Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.4.1 дэх заалт

4.	Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгох үйл ажиллагааг цахимжуулах, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор "Газрын бирж"-ийн цахим систем /www.mle.mn/ -ийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах	НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 23.2.7 "Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Газрын биржийн үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулах" дах заалт; Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 152 дугаар тогтоол
5.	Газрын нөөц санг бүрдүүлэх, газрын дуудлага худалдааны үйл ажиллагааны зардал, газар чөлөөлөх нөхөх олговрын хөрөнгө, газрын нөөц санг бий болгох зорилгоор газар хөгжүүлэх санг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, газар, үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийн үнийн мэдээллийг цуглуулах, мэдээллийн санд бүртгэх	НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 2022 оны А/219, А/1602 дугаар тушаал, захирамж
Гурав. Хот байгуулалт, газар зохион байгуулалтын чиглэлээр хийгдэх ажил				
Хот байгуулалтын чиглэлээр:				
6.	Авто замын түржрэлийг бууруулах ажлын хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд авто зогсоол төлөвлөх, барих ажлыг иргэн, хуулийн этгээдийн оролцоотойгоор хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	НХБХСГ, НГЗБА, ДЗДТГ	I-IV улиралд	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны "Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд авто зогсоол төлөвлөх барьж байгуулах журам"-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай 175 дугаар тогтоол
7.	Нийслэлийн нутаг дэвсгэрт явган зам болон дугуйн зам, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн тохижилт, ногоон байгууламжийн газрын байршлын судалгааг гаргаж, холбогдох ажлыг зохион байгуулах	ЗАА, НХБХСГ, НГЗБА, ДЗДТГ, ДГЗБА	I-IV улиралд	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд
Газар зохион байгуулалтын чиглэлээр:				
8.	Хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах	НГЗБА, НБОГ, ДЗДТГ, ДГЗБА	I-IV улиралд	Хөрсний хүнд металлын бохирдлыг бууруулах чиглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах
9.	Газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээ шинэчлэх үйл ажиллагаанд хамрагдаагүй үлдсэн газар эдлэх эрхийн үнэмлэхтэй, тухайн газраа олон жил амьдарсан боловч газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээ авч байгаагүй иргэдийн газар эзэмших эрхийг хууль тогтоомжид заасан хугацаагаар холбогдох журмын дагуу шинэчлэн олгох	НГЗБА	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 "Иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар үнэ төлбөргүй эзэмшүүлэх газрын хэмжээ 0,07 га-гаас илүүгүй байна" дэх хэсэг
10.	Нийслэлийн нутаг дэвсгэрт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд хамрагдсан газар нутгийн судалгааг гарган, цаашид авах арга хэмжээний талаар санал бэлтгэн, холбогдох шийдвэрийг гаргуулах, чанарын төлөвлөгөөт хянан баталгааг Баянгол, Сүхбаатар, Хан-Уул,	НГЗБА, ДЗДТГ, ДГЗБА	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 58.7 "Газар эзэмшигч, ашиглагч нь газрынхаа төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг өөрийн хөрөнгөөр, анх удаа иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад олгож байгаа болон бусад газрын

	Сонгинохайрхан, Налайх, Багануур, Багахангай дүүргийн нутаг дэвсгэрт зохион байгуулах			төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг улсын буюу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ" дах заалт
11.	Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлтийг баталгаажуулах, газрын төлөв байдал, чанар хэрхэн өөрчлөгдөж байгаад хяналт тавьж ажиллах, зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулах	НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 58.6 "Эрхийн гэрчилгээгээр эзэмшиж, ашиглаж буй газрын төлөв байдал, чанарыг газар эзэмшигч, ашиглагч, улсын болон аймаг, нийслэл, сумын тусгай хэрэгцээний газрын төлөв байдал, чанарыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэл, сумын Засаг дарга, бусад газрын төлөв байдал, чанарыг тухайн шатны Засаг дарга тус тус хариуцна" заалт
12.	2025 онд Иргэнд гэр бүлийн хэрэгцээнд 622 болон зуслангийн зориулалтаар 762 нэгж талбарыг эзэмшүүлэх	НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Төлөвлөлтийн нэгж талбарууд хянагдаж дуусаагүй
Дөрөв. Газар өмчлөлийн чиглэлээр хийгдэх ажил				
13.	Газар өмчилсөн иргэдийн шийдвэрийн төсөл бэлтгэх ажлын хэсгийн хурлаар гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшиж байгаа газрыг өмчлүүлэх, кадастрын зурагт өөрчлөлт оруулах асуудлыг тухай бүрд нь хэлэлцэж шийдвэрлэх	НЗДТГ, НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	"Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль", "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль" - ийн хэрэгжилтийг хангах
14.	Улаанбаатар хотын ногоон бүс буюу зуслангийн амнуудад газар эзэмшиж байгаа иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг өмчлүүлэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах	НЗДТГ, НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 25 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 101, 181 дүгээр тогтоол, Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу
15.	Газар өмчлөх иргэдийн санал, хүсэлтийг цахим системээр хүлээн авах, олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэх	НЗДТГ, НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоол
16.	Бүтээн байгуулалтын ажлын нөлөөлөлд өртсөн, өмнөх онуудын газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өмчлүүлэхээр тусгагдсан, газрын эрхийн аливаа зөрчилгүй талаарх гэрээ дүгнэсэн акт, иргэний хүсэлтийг үндэслэн эзэмшиж буй газрыг өмчлүүлэх	НЗДТГ, НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Нийслэлийн 2021-2025 онд хөгжүүлэх таван үндсэн чиглэлийн 9.6 дэх заалт; "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль", "Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль" - ийн хэрэгжилтийг хангах
Тав. Газрын кадастрын чиглэлээр хийгдэх ажил				
17.	Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн зам талбай, нийгмийн хангамжийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, түүх соёлын дурсгалт газрын хамгаалалтын бүс, хориглолтын бүсүүдэд барилгын норм	НЗДТГ, НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1-д "Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан өөрийн шийдвэр, үйлдэл /эс үйлдэхүй/-ээрээ газрын тухай хууль тогтоомж,

	<p>дүрэм зөрчиж газар эзэмших, ашиглах эрх олгосон нийслэл, дүүргийн Засаг даргын захирамжийг судлан газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний талбайг хэсэгчлэн буюу бүхлээр нь хүчингүй болгох зэрэг холбогдох арга хэмжээг авах</p>	<p>НЗДТГ, НОБГ, НГЗБА, ДЗДТГ, ДГЗБА</p>	<p>I-IV улиралд</p>	<p>газар эзэмшигч, ашиглагчийн хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг байгууллага, албан тушаалтан өөрөө буюу түүний дээд шатны байгууллага, албан тушаалтан, эсхүл шүүх уг хууль бус шийдвэрийг хүчингүй болгож, үйлдлийг таслан зогсооно” заалт</p>
<p>18.</p>	<p>Үерээс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангуулах, шар усны үерт өртөж болзошгүй нэгж талбарыг чөлөөлөх, нүүлгэн шилжүүлэх</p>	<p>НЗДТГ, НОБГ, НГЗБА, ДЗДТГ, ДГЗБА</p>	<p>I-IV улиралд</p>	<p>Барилга, хот байгуулалтын сайд /хуучнаар/-ын 2023 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 2023/02 дугаартай албан даалгавар</p>
<p>19.</p>	<p>Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фотомониторингийн аргаар үнэлэх ажлыг зохион байгуулах, тайланг ГЗБГЗЗБЕГ-т хүргүүлэх</p>	<p>НГЗБА, ДГЗБА</p>	<p>I-IV улиралд</p>	<p>Газрын тухай хуулийн 23.2.10 “газрыг хамгаалах, нөхөн сэргээх, газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих,” 23.2.21 “газрын төлөв байдал, чанарыг тодорхойлох, үнэлгээ өгөх, чанарын өөрчлөлтийг улсын хэмжээнд хянан дүгнэх үүрэг бүхий хяналт шинжилгээ /мониторинг/-ий сүлжээ ажиллуулах;”</p>
<p>20.</p>	<p>Газрын кадастрын мэдээллийн санд хяналт тавих ажлын хэсгийн хурлаар иргэн, хуулийн этгээдийн эзэмшиж, ашиглаж буй газрын байршлын кадастрын зургийг шинээр бүртгэх, эргэлтийн цэг өөрчлөх, устгах, сэргээхтэй холбоотой асуудлыг тухай бүр хэлэлцэн шийдвэрлэх</p>	<p>НГЗБА, ДГЗБА</p>	<p>I-IV улиралд</p>	<p>Газрын тухай хууль болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын тушаалыг хэрэгжүүлэх</p>
<p>21.</p>	<p>Нийслэлийн нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ханган газар ашиглалтыг сайжруулах, авто зам болон явган хүний зам талбайг нэмэгдүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах болон тохижилтын ажил гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх зорилгоор газрын зөрчил арилгах, орчны аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээг зохион байгуулах</p>	<p>НГЗБА, НХБХСГ, ДГЗБА</p>	<p>I-IV улиралд</p>	<p>Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 9.4.2 дахь заалт</p>
<p>22.</p>	<p>Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд хот төлөвлөлт, орчны стандарт алдагдсан орон сууцны хорооллуудад газар чөлөөлөлт хийж, орчны төлөвлөлтийг стандартад нийцүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, газар ашиглалтыг сайжруулах, тохижилт хийх нөхцөл боломжийг бий болгох, авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор нийтийн эдэлбэр газар, гудамж, зам талбайд зөвшөөрөлгүйгээр байрлуулсан зөөврийн байгууламжууд, түргэн үйлчилгээний цэгийн зөвшөөрөл өгсөн эрх бүхий байгууллагад албадан чөлөөлүүлэх санал хүргүүлэх, авто болон явган хүний зам хааж байрлуулсан хашаа, хайс, объектуудыг буулгах,</p>	<p>НГЗБА, ДЗДТГ, ДГЗБА</p>	<p>I-IV улиралд</p>	<p>Газрын тухай хуулийн 56.5 “Зохих зөвшөөрөлгүй барилга байгууламж барьсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар чөлөөлөх тухай мэдэгдлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн тохиолдолд тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллага заасан хугацаанд багтааж газар чөлөөлөх үүрэгтэй; 57.4. Мэдэгдэлд заасан хугацаанд газрыг чөлөөлөөгүй бол аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга уг газрыг албадан чөлөөлөх арга хэмжээ авч, холбогдох зардлыг гэм буруутай этгээдээс гаргуулна” дэх заалт; Монгол Улсын Их Хурлын</p>

	нүүлгэн шилжүүлэх, газрыг чөлөөлж зөрчлийг арилгах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах			2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.1.2 заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 34 дүгээр тогтоол
23.	Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний хүрээнд төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, тариалангийн талбайн зориулалтаар эзэмшиж ашиглаж байгаа иргэн, хуулийн этгээдийн газарт судалгаа хийж зөрчилтэй нэгж талбаруудын газрын эрхийг хүчингүй болгох, мөн төсөл хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, байгууллагад эзэмшүүлэх ажлыг зохион байгуулах	ХХААХҮЯ НЗДТГ, НХХААГ, НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Монгол Улсын Их Хурлын 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай" 36 дугаар тогтоол
Зургаа. Газрын зураглал, мэдээллийн технологийн чиглэлээр хийгдэх ажил				
24.	Нийслэлийн нутаг дэвсгэрт байрлаж байгаа геодезийн байнгын цэг, тэмдэгтийн тооллого, хэдгалалт, хамгаалалтад хяналт тавих үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах	НЗДТГ, НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Геодези, зураг зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх
25.	Иргэн хуулийн этгээдэд зориулсан газрын удирдлагын нэгдсэн цахим системд хөгжүүлэлт хийж газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгч хувь хүн, хуулийн этгээдүүд өөрийн газартай холбоотой төрийн үйлчилгээг газрын удирдлагын нэгдсэн цахим системийг ашиглаж хүсэлт гаргах, хамааралтай мэдээ мэдээллийг зохих журмын дагуу түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлэх	НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Засгийн Газрын 2020 оны 110 дугаар тогтоол
26.	Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газрын орон зайн мэдээллийг бүрдүүлж, газрын удирдлагын нэгдсэн мэдээллийн санд оруулах	НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Засгийн Газрын 2017 оны 289 дугаар тогтоол
27.	Нийслэл дэх газар зүйн нэрийн хээрийн тодруулалтын ажил болон газар зүйн нэрийн зөвлөлийн хурлыг зохион байгуулах	НГЗБА, ДГЗБА	I-IV улиралд	Геодези, зураг зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх
Долоо. Газрын татвар, төлбөр, үнэлээний чиглэлээр хийгдэх ажил				
28.	Газрын кадастрын мэдээллийн системд газар эзэмшигч, ашиглагч нарын бүртгэлийн алдаагүй, үндсэн нэгж талбарын газрын төлбөрийн ногдуулалт, нэхэмжлэхийг үүсгэх ажлыг зохион байгуулах	НГЗБА	I-IV улиралд	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд
29.	Засгийн Газрын 2018 оны 182 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12/39 дүгээр тогтоол шинэчлэгдсэн тохиолдолд газрын үнэлээний итгэлцүүр шинэчлэн батлагдсантай холбоотойгоор иргэн,	НЗДТГ, НГЗБА	I-IV улиралд	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд

	хуулийн этгээдтэй байгуулсан газар эзэмшүүлэх, ашиглуулах гэрээнд ногдуулсан газрын төлбөрийг шинэчлэх, гэрээг дүгнэх, тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулах		
--	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--	--

ХОЁР. ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

2.1 Өмчлүүлэх газрын байршил, зориулалт, хэмжээ								
Д/Д	Дүүрэг	Хороо	Газрын байршил	Иргэдийн тоо	Газрын хэмжээ /га/	ЗОРИУЛАЛТ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага
1		7	Хувьсгалчдын А-Г гудамж	2	0.0505			
2		9	Дэнж, Усан сангийн гудамж	2	0.0989			
3		10	Дэнж	3	0.1332			
4		13	Сургуулийн гудамж, Хайлааст	5	0.27			
5		14	Хайлаастын гудамж, Хандгайт	2	0.0982			
6		15	Жаргалантын гудамж	6	0.2647			
7		16	Согоотын гудамж	13	0.7749			
8		17	Зүрх уул, Баянхайрхан, Сурагчийн гудамж	2	0.0876			
9	Чингэлтэй	18	Яргайтын гудамж	3	0.1607	Гэр бүлийн хэрэгцээ	I-IV улиралд	НГЗБА, ЧДГЗБА
10		19	Тахилт, Доод, Дээд, Салхитын гудамж	12	0.6577			
11		20	Хувьсгалчдын-Г-ийн гудамж	7	0.395			
12		21	Булагийн гудамж	12	0.5292			
13		22	Согоотын гудамж	3	0.1176			
14		23	Чингэлтэй, Зүрх уул, Сурагч, Баянхайрханы гудамж	15	0.9178			
15		24	Шадивлан, Гүнт, Яргайтын богино, Майхан толгой, Жигжид, Ар согоот, Зуун мод	38	3.0101			
			Дүн	125	7.57			

2.1a Шинээр эзэмшүүлэх газрын байршил, зориулалт, хэмжээ								
Д/Д	Дүүрэг	Хороо	Эзэмшүүлэх газрын байршил	Зориулалт	Иргэдийн тоо	Газрын хэмжээ /га/	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага
1	Чингэлтэй	7	Хувьсгалчдын А-Г		31	1.35		

24		24	Майхан толгой		70	3.8			
25		24	Ойн булаг		3	0.17			
				Дүн	1124	54.47			
2.16 Орц, гарц, гаргах									
д/д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Чөлөөлөх объектын тоо	газрын хэмжээ /га/	Зөрчлийн хэлбэр	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага		
1.	Чингэлтэй дүүргийн 23 дугаар хороо	Чингэлтэй	6	0.3	Орц, гарц	I-IV улиралд	ДЗДТГ, ДГЗБА		
2.	Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хороо	Ар согоот	5	0.25	Орц, гарц	I-IV улиралд	ДЗДТГ, ДГЗБА		
3.	Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хороо	Зуун мод	5	0.25	Орц, гарц	I-IV улиралд	ДЗДТГ, ДГЗБА		
4.	Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хороо	Шөдөвлан	10	0.5	Орц, гарц	I-IV улиралд	ДЗДТГ, ДГЗБА		
5.	Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хороо	Жигжид	10	0.5	Орц, гарц	I-IV улиралд	ДЗДТГ, ДГЗБА		
6.	Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хороо	Яргайт	7	0.35	Орц, гарц	I-IV улиралд	ДЗДТГ, ДГЗБА		
7.	Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хороо	Яргайтын богино	6	0.3	Орц, гарц	I-IV улиралд	ДЗДТГ, ДГЗБА		
8.	Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хороо	Гүнт	15	0.75	Орц, гарц	I-IV улиралд	ДЗДТГ, ДГЗБА		
9.	Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хороо	Майхан толгой	5	0.25	Орц, гарц	I-IV улиралд	ДЗДТГ, ДГЗБА		
				Дүн	69	3.45			
2.18 Зөрчил, аршгах									
д/д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Чөлөөлөх объектын тоо	Объектын төрөл	Зөрчлийн хэлбэр	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага		
1.	Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо	A4 дүгээр байрны зүүн талд	14	Тоосгон гарааш	Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа	I-IV улиралд	ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА		
2.	Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо	8 дугаар байрны зүүн талд	3	Тоосгон гарааш	Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа	I-IV улиралд	ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА		

3.	Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороо	12 дугаар байрны хойд талд	6	Тоосгон гарааш	Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа	I-IV улиралд	ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА
4.	Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороо	46 дугаар байрны хойд талд	4	Тоосгон гарааш	Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа	I-IV улиралд	ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА
5.	Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо	ХСТЛ ХХК	25м	Бетон суурьтай блокон хашаа	Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа	I-IV улиралд	ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА
6.	Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо	Урт цагааны хойд талд	50	Бетон суурьтай блокон хашаа	Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа	I-IV улиралд	ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА
7.	Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороо	Бишрэлт их дэлгүүрийн хойд талд дипломат-95	210	Бетон суурьтай блокон хашаа	Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа	I-IV улиралд	ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА
8.	Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороо	5 дугаар байрны урд талд	4	Төмөр хашаа	Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа	I-IV улиралд	ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА
9.	Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороо	41 дүгээр байрны хашаа	243	Төмөр хашаа	Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа	I-IV улиралд	ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА
10.	Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороо	Рич зочид буудал	29	Бетон суурьтай блокон хашаа	Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа	I-IV улиралд	ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА
11.	Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороо	29 дүгээр байр, Төрийн орон сууцны корпорацийн байр	69	Төмөр хашаа	Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа	I-IV улиралд	ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА
12.	Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороо	33 дугаар байр	140	Төмөр хашаа	Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа	I-IV улиралд	ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА
13.	Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороо	61 дүгээр байрны урд талд	100	Төмөр хашаа	Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа	I-IV улиралд	ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА
14.	Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороо	40 дүгээр байрны зүүн талд	18	Төмөр хашаа	Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа	I-IV улиралд	ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА
15.	Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороо	43, 45 дугаар байрны дунд	25	Төмөр хашаа	Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа	I-IV улиралд	ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА

16.	Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороо	20 дугаар байрны хойд талд	18	бусад	Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа	I-IV улиралд	ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА
17.	Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороо	50 дугаар сургуулийн урд талд	100	Төмөр хашаа	Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа	I-IV улиралд	ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА
18.	Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороо	62А дугаар байр	50	Төмөр хашаа	Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа	I-IV улиралд	ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА
19.	Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороо	35 дугаар байрны зүүн талд	60	Төмөр хашаа	Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа	I-IV улиралд	ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА
20.	Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороо	Монгол телевиз	100	Төмөр хашаа	Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа	I-IV улиралд	ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА
21.	Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороо	Их тойруу гудамж	14	Төмөр хашаа	Зөвшөөрөлгүй ашиглаж байгаа	I-IV улиралд	ДЗДТГ, ДЦГ, ДГЗБА
ДҮН			1255				

2.2а Төрийн болон төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд

д/д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ /га/	Хугацаа	Хариуцах байгууллага
1.	Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хороо	Цагаан байрны хойно	Төр захиргааны байр	4.8	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
2.	Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хороо	Цагаан байрны хойно	Өрхийн эрүүл мэндийн төв	0.12	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
3.	Чингэлтэй дүүргийн 10 дугаар хороо	Биеийн тамир спортын хорооны орчим	Өрхийн эрүүл мэндийн төв	0.15	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
4.	Чингэлтэй дүүргийн 10 дугаар хороо	39 дүгээр сургууль	39 дүгээр сургуулийн Б байрны өргөтгөл	0.31	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
5.	Чингэлтэй дүүргийн 11 дүгээр хороо	Өрхийн эрүүл мэндийн төв	Өрхийн эрүүл мэндийн төв	0.125	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
6.	Чингэлтэй дүүргийн 12 дугаар хороо	Усан бассейнтай цогцолборын барилга 61 дүгээр сургууль	Боловсрол	0.19	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
7.	Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хороо	Эрт илрүүлэг, оношилгооны төвийн баруун талд	Эмч хотхон (Эмнэлгийн ажилчдын түр орон сууц)	0.155	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
8.	Чингэлтэй дүүргийн 15 дугаар хороо	Усан бассейнтай цогцолборын барилга 49 дүгээр сургууль	Боловсрол	0.25	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ

9.	Чингэлтэй дүүргийн 16 дугаар хороо	Хоймор хайрхан ОНӨТҮГ-ын орчим	Ахмадын амралт сувиллын барилга	54.009	II-IV улирал	НГЗБА, ЧДЗДТГ
10.	Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо	Усан бассейнтай цогцолборын барилга 117 дугаар сургууль	Боловсрол	0.216	II-IV улирал	НГЗБА, ЧДЗДТГ
11.	Чингэлтэй дүүргийн 20 дугаар хороо	Өрхийн эрүүл мэндийн төв	Өрхийн эрүүл мэндийн төв	0.11	II-IV улирал	НГЗБА, ЧДЗДТГ
12.	Чингэлтэй дүүргийн 20 дугаар хороо	Усан бассейнтай цогцолборын барилга 149 дүгээр сургууль	Боловсрол	0.4	II-IV улирал	НГЗБА, ЧДЗДТГ
13.	Чингэлтэй дүүргийн 23 дугаар хороо	Усан бассейнтай цогцолборын барилга 140-р сургууль	Боловсрол	0.3	II-IV улирал	НГЗБА, ЧДЗДТГ
14.	Чингэлтэй дүүргийн 23 дугаар хороо	Шар хагтын ам	Ахмадын амралт сувиллын барилга	8.7871	II-IV улирал	НГЗБА, ЧДЗДТГ
15.	Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хороо	Майхан толгой орчим	Хүүхэдэйн театр, номын сан бүхий хүүхдийн зуслангийн цогцлоор барилга	0.4	II-IV улирал	НГЗБА, ЧДЗДТГ
-Нийт-						
70.3221						
2.1а Үер, халиа дошингийн эрсдэлтэй бүсэд өртсөн иргэдийг нүүлгэн шилжүүлэх газрын байршил, хэмжээ						
Д/Д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ /га/	Хугацаа	Хариуцах байгууллага
1.	Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо	Доод салхит орчим	Иргэний ахуй	0.06	II-IV улирал	ЧДЗДТГ

2.4 Нийтийн эдэлбэр газрын байршил, хэмжээг тогтоох						
Д/Д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Зориулалт	Газрын хэмжээ /га/	Хугацаа	Хариуцах байгууллага
1.	Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо	Сансар КАТВ-ын баруун урд талын гараашны газар чөлөөлөлт	Автомашинны зогсоол	0.022	I-IV улирал	НГЗБА, ХБХГ, ЧДЗДТГ
2.	Чингэлтэй дүүргийн 3 дугаар хороо	2 дугаар 40 мянгат 6, 15 дугаар байрны дунд авто машины зогсоол	Автомашинны зогсоол	0.14	I-IV улирал	НГЗБА, ХБХГ, ЧДЗДТГ
3.	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороо	Зурагтын шинэ эцсийн буудлаас хуучин эцсийн буудал хүртэл явган зам	Явган зам	0.105	I-IV улирал	НГЗБА, ХБХГ, ЧДЗДТГ

4.	Чингэлтэй дүүргийн 10 дугаар хороо	Чингэлтэйн 1, 4, 6, 7, 8, 14 гудамж, 156 ус түгээх байр	Дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилгын гадна инженерийн шугам	2.3	II-IV улирал	НГЗБА, ЧДЗДТГ
5.	Чингэлтэй дүүргийн 11 дүгээр хороо	Хорооны цогцолбор байршлын ард талд	Автомашинны зогсоол, тоглоомын талбай	0.28	II-IV улирал	ЧДЗДТГ
6.	Чингэлтэй дүүргийн 12 дугаар хороо	Бага сургууль, цэцэрлэгийн дэргэд автозам, зогсоол	Автозам, зогсоол	0.315	II-IV улирал	ЧДЗДТГ
7.	Чингэлтэй дүүргийн 13 дугаар хороо	13 дугаар хороо, 17 дугаар сургууль, 56 дугаар цэцэрлэг, Цагдаагийн 2 дугаар хэлтэс, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын орчим	Автомашинны зогсоол, тоглоомын талбай	0.07	II-IV улирал	ЧДЗДТГ
8.	Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хороо	Иргэд, хүүхэд, залуучууд, ахмад настны хөгжлийн төв	Автомашинны зогсоол	1.2	II-IV улирал	ЧДЗДТГ
9.	Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хороо	126 дугаар цэцэрлэгийн гадна хүүхдийн тоглоомын талбай болон авто зогсоол	Автомашинны зогсоол	0.11	II-IV улирал	ЧДЗДТГ
10.	Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хороо	Эрт илрүүлэг, оношилгооны төв	Автомашинны зогсоол	0.1	II-IV улирал	ЧДЗДТГ
11.	Чингэлтэй дүүргийн 15 дугаар хороо	Жаргалантын гудамж	Тоглоомын талбай	0.03	II-IV улирал	ЧДЗДТГ
12.	Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороо	37 дугаар сургуулийн хойд талд авто зогсоол	Автомашинны зогсоол	0.09	II-IV улирал	ЧДЗДТГ
13.	Чингэлтэй дүүргийн 17 дугаар хороо	Чингэлтэй хайрхан өгсөх зам орчим	Ногоон байгууламж	1.0	II-IV улирал	ЧДЗДТГ
14.	Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо	Хайрхан хөгжлийн төв 1	Автомашинны зогсоол	0.126	II-IV улирал	ЧДЗДТГ
15.	Чингэлтэй дүүргийн 20 дугаар хороо	291 дүгээр цэцэрлэгийн урд талд авто зам, зогсоол	Автозам, зогсоол	0.09	II-IV улирал	ЧДЗДТГ
16.	Чингэлтэй дүүргийн 22 дугаар хороо	Хорооны барилгын дэргэд	Автомашинны зогсоол	0.28	II-IV улирал	ЧДЗДТГ
17.	Чингэлтэй дүүргийн 23 дугаар хороо	140 дүгээр сургуулийн хойно цэцэрлэг, сургуулийн орчмын ногоон байгууламж, тохижилт, үерийн аюулгүй бүс	Ногоон байгууламж, тохижилт, үерийн хамгаалалт	0.61	II-IV улирал	ЧДЗДТГ
18.	Чингэлтэй дүүргийн 24 дүгээр хороо	Хорооны барилгын дэргэд	Автомашинны зогсоол	0.06	II-IV улирал	ЧДЗДТГ
Нийт				7,048		
2.5/Авто зам, замын байгууламж						
Д/д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Хэмжээ /км/	Зориулалт	Хугацаа	Хариуцах байгууллага

1.	Чингэлтэй дүүргийн 7, 8, 9, 10 дугаар хороо	Тасганы овооноос хороодын нутаг дэвсгэрийн хилийн цэсийн дагуу Самбалхүндэвийн эргэмжийн газрын авто замтай нийлэх чулуун болон хатуу хучилттай авто зам	7.49	Автозам	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
2.	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороо	Зурагтын шинэ эцсийн буудлаас хуучин эцсийн буудал хүртэлх явган зам	0.105	Явган зам	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
3.	Чингэлтэй дүүргийн 10 дугаар хороо	Цагаан байрны хойд уулзвараас далан дагаад Хүчит шонхор захын уулзвар хүртэлх автозам	2.3	Автозам	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
4.	Чингэлтэй дүүргийн 13, 14 дүгээр хороо	Дүүргийн 13, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хийгдэх 250м автозам, гүүрийн ажил	0.19	Автозам	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
5.	Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хороо	126 дугаар цэцэрлэгээс 103 түргэн тусламжийн төв туслах зам	0.34	Автозам	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
6.	Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хороо	Иргэд, хүүхэд залуучууд, ахмад настны хөгжлийн төвөөс Эрт илрүүлэг оношилгооны төв хүртэлх туслах зам	0.075	Автозам	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
7.	Чингэлтэй дүүргийн 16 дугаар хороо	Хайлаастын гудамжнаас 246 дугаар цэцэрлэг хүртэлх авто зам	1.47	Автозам	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
8.	Чингэлтэй дүүргийн 18 дугаар хороо	Хайлааст-Чингэлтэй холбосон авто замаас 37 дугаар сургууль хүртэлх автозам	0.63	Автозам	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
9.	Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо	Тахилт 2 дугаар гудамж	0.14	Автозам	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
10.	Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо	Гэр хорооллын дундах авто замын бүтцийг сайжруулах, шинэчлэх	1.7	Автозам	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
11.	Чингэлтэй дүүргийн 18 дугаар хороо	Яргайтын 16 дугаар гудамжнаас 15 дугаар хороо, Жаргалантын 32 дугаар гудамж хүртэлх автозам	0.19	Автозам	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
Нийт			7.7			

ГУРАВ. НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ, ГАЗРЫН БАЙРШИЛ, ХЭМЖЭЭ

3.1 Барилга байгууламжийн газрыг чөлөөлөх							
д/д	Дүүрэг, хороо	Газрын байршил	Чөлөөлөх нэгж талбарын тоо	Чөлөөлөх газрын хэмжээ /га/	Зориулалт	Хугацаа	Хариуцах байгууллага
1.	Чингэлтэй дүүргийн дүгээр хороо	Цагаан байрны хойно	14	4.8	Төр байрны захиргааны	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
2.	Чингэлтэй дүүргийн дүгээр хороо	Цагаан байрны хойно	4	0.12	Өрхийн эрүүл мэндийн төв	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ

3.	Чингэлтэй дүүргийн дугаар хороо	10	Биеийн тамир хорооны орчим	спортын	3	0.15	Өрхийн эрүүл мэндийн төв	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
4.	Чингэлтэй дүүргийн дугаар хороо	10	39 дүгээр сургууль		4	0.31	39 дүгээр сургуулийн өргөтгөл	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
5.	Чингэлтэй дүүргийн дүгээр хороо	11	Өрхийн эрүүл мэндийн төв		3	0.125	Өрхийн эрүүл мэндийн төв	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
6.	Чингэлтэй дүүрэг, 14 хороо		Эрт илрүүлэг, оношилгооны төвийн баруун талд		6	0.155	Эмч хотхон (Эмнэлгийн ажилчдын түр орон сууц)	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
7.	Чингэлтэй дүүргийн дугаар хороо	12	61 дүгээр сургууль орчим		5	0.19	Усан бассейнтай цогцолборын барилга 61 дүгээр сургууль	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
8.	Чингэлтэй дүүргийн дугаар хороо	15	49 дүгээр сургууль орчим		6	0.4	Усан бассейнтай цогцолборын барилга 49 дүгээр сургууль	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
9.	Чингэлтэй дүүргийн дүгээр хороо	19	117 дугаар сургууль орчим		3	0.216	Усан бассейнтай цогцолборын барилга 117 дугаар сургууль	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
10.	Чингэлтэй дүүргийн дугаар хороо	20	149 дүгээр сургууль орчим		6	0.4	Усан бассейнтай цогцолборын барилга 149 дүгээр сургууль	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
11.	Чингэлтэй дүүргийн дугаар хороо	23	140 дүгээр сургууль орчим		4	0.3	Усан бассейнтай цогцолборын барилга 140 дүгээр сургууль	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
3.2 Зам, замын байууламжийн газрыг чөлөөлөх									
12.	Чингэлтэй дүүргийн дугаар хороо	23	Чингэлтэй зүрх уул		9	0.63	Цэцэрлэг, сургуулийн орчмын ногоон байгууламж, тохижилт, үерийн аюулгүй бус	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
13.	Чингэлтэй дүүргийн дугаар хороо	7	Зурагтын шинэ буудлаас хуучин буудал хүртэлх явган зам	эцсийн эцсийн	3	0.105	Явган зам	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
14.	Чингэлтэй дүүргийн дугаар хороо	10	Цагаан байрны хойд уулзвараас далан дагаад Хүчит шонхор захын уулзвар хүртэлх автозам	хойд дагаад	10	2.3	Автозам	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ

15.	Чингэлтэй дүүргийн 13, 14 дүгээр хороо	Дүүргийн 13, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хийгдэх 250м автозам, гүүрийн ажил	2	0.19	Автозам	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
16.	Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хороо	126 дугаар цэцэрлэгээс 103 түргэн тусламжийн төв туслах зам	13	0.34	Автозам	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
17.	Чингэлтэй дүүргийн 16 дугаар хороо	Хайлаастын гудамжнаас 246 дугаар цэцэрлэг хүртэлх авто зам	21	1.47	Автозам	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
18.	Чингэлтэй дүүргийн 18 дугаар хороо	Хайлааст-Чингэлтэй холбосон авто замаас 37 дугаар сургууль хүртэлх автозам	9	0.63	Автозам	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
19.	Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо	Тахилт 2 дугаар гудамж	2	0.14	Автозам	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
20.	Чингэлтэй дүүргийн 18 дугаар хороо	Яргайтын 16 дугаар гудамжнаас 15 дугаар хороо, Жаргалантын 32 дугаар гудамж хүртэлх автозам	4	0.19	Автозам	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
21.	Чингэлтэй дүүргийн 6 дугаар хороо	СУИС-ийн баруун талд Анкара 1-93	1	0.007	Автозам өргөлтөх	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
22.	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хороо	Зурагтын шинэ эцсийн буудлаас хуучин эцсийн буудал хүртэл явган зам	19	0.105	Дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилгын гадна инженерийн шугам	I-IV улиралд	НГЗБА, ХБХГ, ЧДЗДТГ
23.	Чингэлтэй дүүргийн 10 дугаар хороо	Чингэлтэйн 1, 4, 6, 7, 8, 14 гудамж, 156 ус түгээх байр	16	2.3	Автозам, зогсоол	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
24.	Чингэлтэй дүүргийн 11 дүгээр хороо	Хорооны цогцолбор байрны ард тал	4	0.28	Автомашини зогсоол	II-IV улиралд	НГЗБА, ЧДЗДТГ
25.	Чингэлтэй дүүргийн 12 дугаар хороо	Бага сургууль, цэцэрлэгийн дэргэд автозам, зогсоол	3	0.315	Автомашини зогсоол, тоглоомын талбай	II-IV улиралд	ЧДЗДТГ
26.	Чингэлтэй дүүргийн 13 дугаар хороо	Хайлааст амбулаторийн урд Дашваанжил ХХК-ийн дэлгүүр	1	0.03	Автомашини зогсоол	II-IV улиралд	ЧДЗДТГ
27.	Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хороо	Иргэд, хүүхэд, залуучууд, ахмад настны хөгжлийн төв	2	1.2	Автомашини зогсоол	II-IV улиралд	ЧДЗДТГ
28.	Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хороо	Эрт илрүүлэг, оношилгооны төв	2	0.1	Автомашини зогсоол	II-IV улиралд	ЧДЗДТГ

29.	Чингэлтэй дүүргийн дугаар хороо	17	37 дугаар сургуулийн спорт заалны авто зогсоол	4	0.17	Автомашинны зогсоол	II-IV улиралд	ЧДЗДТГ
30.	Чингэлтэй дүүргийн дүгээр хороо	19	Хайрхан хөгжлийн төв 1	3	0.126	Автомашинны зогсоол	II-IV улиралд	ЧДЗДТГ
31.	Чингэлтэй дүүргийн дугаар хороо	22	Хорооны барилгын дэргэд	4	0.28	Автомашинны зогсоол	II-IV улиралд	ЧДЗДТГ
3.3 Ногоон байгууламжийн чиглэлээр газар чөлөөлөх								
32.	Чингэлтэй дүүргийн дугаар хороо	17	Чингэлтэй хайрхан өгсөх зам орчим	9	1.0	Ногоон байгууламж, явган зам	II-IV улиралд	ЧДЗДТГ
33.	Чингэлтэй дүүргийн дүгээр хороо	19	Доод сапхит орчим	1	0.13	Үерийн далангийн барилга байгууламж	II-IV улиралд	ЧДЗДТГ
34.	Чингэлтэй дүүргийн дугаар хороо	23	140 дүгээр сургуулийн хойно цэцэрлэг, сургуулийн орчмын ногоон байгууламж, тохижилт, үерийн аюулгүй бүс	9	0.61	Ногоон байгууламж, тохижилт, үерийн хамгаалалт	II-IV улиралд	ЧДЗДТГ
Дүн				209	19.814			

3.4 Дэд төсүүдийн газрыг чөлөөлөх								
№	Дүүрэг, хороо	Газрын байршил	Чөлөөлөх нэгж талбарын тоо	Чөлөөлөх газрын хэмжээ/га/	Зориулалт	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага	
1.	Сүхбаатар дүүргийн 13, 14 дүгээр хороо Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороо	Сэлбэ дэд төв	2206	158.0	Дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд инженерийн болон нийгмийн дэд бүтцийн барилга, байгууламж	I-IV улиралд	НГЗБА, НХОГ, УБХГХХХОДХТ	
2.	Сүхбаатар дүүргийн 12, 13 дугаар хороо, Чингэлтэй дүүргийн 11, 12, 13, 14, 15, 16, 18, 22 дугаар хороо	Сэлбэ дэд төв орчмын хоёрдугаар ээлж	10741	501.0	Дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд инженерийн болон нийгмийн дэд бүтцийн барилга, байгууламж	I-IV улиралд	НГЗБА, НОСК ХК	
3.	Чингэлтэй дүүргийн 10, 11, 12, 13 дугаар хороо	Дэнжийн 1000 дэд төв	363	12.8	Дэд төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд инженерийн болон нийгмийн дэд бүтцийн барилга, байгууламж	I-IV улиралд	НГЗБА, НХОГ, УБХГХХХОДХТ	